

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Б.Одгэрэл
Утас: 86032989, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 №УВА-2023/27/НА-СТА-ТЦЗ

танай _____-ны № _____-т

ЗҮҮНХАНГАЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА О.ЦЭРЭНДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200700596

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	101,104,170.00	127,286,546.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	629,257.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	629,257.00	0.00
31210	Төгрөг	629,257.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	620,000.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	9,257.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	100,474,913.00	127,286,546.00
35400	Хангамжийн материал	100,474,913.00	123,289,213.00
35410	Бичиг хэргийн материал	15,123,233.00	14,938,633.00
35420	Аж ахуйн материал	31,028,180.00	35,210,080.00
35440	Түлш, шатах тослох материал	624,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	53,699,500.00	73,140,500.00
35600	Мал амьтад	0.00	3,997,333.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,853,055,302.81	2,129,649,147.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,853,055,302.81	2,129,649,147.05
39200	Биет хөрөнгө	1,828,835,302.81	2,051,890,147.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,776,099,076.39	2,084,065,276.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	-272,997,840.76	-332,904,572.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	287,466,500.00	290,066,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-135,240,693.21	-175,982,660.02
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	284,353,125.40	325,493,875.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-183,173,430.11	-210,259,034.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,660,088.00	106,086,388.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,531,522.90	-44,875,625.41
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,200,000.00	10,200,000.00
39300	Биет бус хөрөнгө	24,220,000.00	77,759,000.00
39301	Програм хангамж	1,710,000.00	1,710,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-870,000.00	-1,005,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	28,330,000.00	82,004,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-4,950,000.00	-4,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,954,159,472.81	2,256,935,693.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,954,159,472.81	2,256,935,693.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,954,159,472.81	2,256,935,693.05
51100	Засгийн газрын оруулсан капитал	430,458,213.17	430,458,213.17
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	430,458,213.17	430,458,213.17
51200	Хуримтлагдсан үр дүн	1,393,134,514.27	1,695,910,734.51
51210	Өмнөх үеийн үр дүн	1,308,680,146.49	1,393,134,514.27
51220	Тайлант үеийн үр дүн	84,454,367.78	302,776,220.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,566,745.37	130,566,745.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,954,159,472.81	2,256,935,693.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	668,107,350.00	911,579,123.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	231,898,400.00	451,519,223.00
120	Нийтлэг татварын бус орлого	231,898,400.00	451,519,223.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	231,898,400.00	451,519,223.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,309,500.00	13,185,140.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	225,588,900.00	438,334,083.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	436,208,950.00	460,059,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,580,150.00	17,180,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,750,000.00	17,180,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,830,150.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	394,628,800.00	442,879,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	394,628,800.00	442,879,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	583,468,395.00	595,802,902.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	553,468,395.00	595,802,902.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539,363,808.88	557,642,959.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,462,359.50	259,705,200.89
210101	Үндсэн цалин	212,917,415.14	179,105,259.39
210102	Нэмэгдэл	0.00	31,429,000.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	5,387,500.00
210104	Урамшуулал	0.00	7,679,740.90
210105	Гэрээт ажлын хөлс	38,544,944.36	36,103,699.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,881,583.97	32,875,369.03
210201	Тэтгэврийн даатгал	23,106,783.00	22,499,205.19
210202	Тэтгэмжийн даатгал	2,563,326.27	2,601,947.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,020,421.08	2,074,698.42
210204	Ажилгүйдлийн даатгал	471,914.09	516,581.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,719,139.53	5,182,937.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,024,896.41	45,786,913.70
210301	Гэрэл, цахилгаан	2,824,818.41	5,958,321.70
210302	Түлш, халаалт	40,200,078.00	39,718,482.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	110,110.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,309,837.00	26,649,660.00
210401	Бичиг хэрэг	2,541,100.00	1,982,450.00
210402	Тээвэр, шатахуун	20,621,965.00	22,460,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,081,890.00	1,052,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	299,800.00	508,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,765,082.00	646,500.00
2105	Нормативт зардал	1,412,400.00	1,261,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	430,000.00	0.00
210502	Хоол, хүнс	982,400.00	1,261,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,694,550.00	7,265,100.00
210604	Урсгал засвар	2,694,550.00	7,265,100.00
2107	Томилолт, зочны зардал	4,636,400.00	3,467,500.00
210702	Дотоод албан томилолт	4,636,400.00	3,467,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,239,724.00	2,149,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,000.00	950,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	109,000.00	109,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	132,110.00	165,310.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,414.00	111,700.00
210807	Газрын төлбөр	403,000.00	653,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	175,702,058.00	178,482,605.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,881,693.00	40,919,200.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	2,350,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,820,365.00	135,213,405.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,104,586.12	38,159,943.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,813,300.00	18,595,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,300.00	16,737,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	1,858,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,291,286.12	19,564,443.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,256,286.12	18,749,443.38
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	35,000.00	815,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,000,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,000,000.00	0.00
221001	Их засвар	30,000,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	84,638,955.00	315,776,220.24
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	184,587.22	13,000,000.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	184,587.22	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	13,000,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	84,454,367.78	302,776,220.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	442,518,450.00	473,245,040.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,309,500.00	12,940,140.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,309,500.00	12,940,140.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,309,500.00	12,940,140.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,309,500.00	12,940,140.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	436,208,950.00	460,304,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,580,150.00	17,425,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,750,000.00	17,180,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,830,150.00	245,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	394,628,800.00	442,879,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	394,628,800.00	442,879,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	406,688,093.00	461,962,797.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406,688,093.00	461,962,797.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,583,506.88	423,802,853.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,462,359.50	259,705,200.89
210101	Үндсэн цалин	212,917,415.14	179,105,259.39
210102	Нэмэгдэл	0.00	31,429,000.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	5,387,500.00
210104	Урамшуулал	0.00	7,679,740.90
210105	Гэрээт ажлын хөлс	38,544,944.36	36,103,699.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,881,583.97	32,875,369.03
210201	Тэтгэврийн даатгал	23,106,783.00	22,499,205.19
210202	Тэтгэмжийн даатгал	2,563,326.27	2,601,947.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,020,421.08	2,074,698.42
210204	Ажилгүйдлийн даатгал	471,914.09	516,581.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,719,139.53	5,182,937.12

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,388,896.41	45,162,913.70
210301	Гэрэл, цахилгаан	2,824,818.41	5,958,321.70
210302	Түлш, халаалт	40,564,078.00	39,094,482.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	110,110.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,626,650.00	26,420,860.00
210401	Бичиг хэрэг	2,591,650.00	1,797,850.00
210402	Тээвэр, шатахуун	20,621,960.00	22,460,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,081,890.00	1,052,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	499,800.00	508,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,831,350.00	602,300.00
2105	Нормативт зардал	2,244,000.00	0.00
210502	Хоол, хүнс	2,244,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,190,200.00	6,940,300.00
210604	Урсгал засвар	4,190,200.00	6,940,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,636,400.00	3,467,500.00
210702	Дотоод албан томилолт	4,636,400.00	3,467,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,179,724.00	2,149,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,083,000.00	950,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	109,000.00	109,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	132,110.00	165,310.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,414.00	111,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00
210807	Газрын төлбөр	403,000.00	653,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,973,693.00	47,081,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,557,193.00	44,731,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,416,500.00	2,350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,104,586.12	38,159,943.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,813,300.00	18,595,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,300.00	16,737,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	1,858,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,291,286.12	19,564,443.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,256,286.12	18,749,443.38
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	35,000.00	815,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	35,830,357.00	11,282,243.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	35,201,100.00	11,911,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,201,100.00	11,911,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	35,201,100.00	11,911,500.00
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,201,100.00	11,911,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-35,201,100.00	-11,911,500.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	0.00

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	629,257.00	-629,257.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	629,257.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	629,257.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	1,308,680,146.49	1,869,705,105.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	1,308,680,146.49	1,869,705,105.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	84,454,367.78	84,454,367.78
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	1,393,134,514.27	1,954,159,472.81
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	1,393,134,514.27	1,954,159,472.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	1,393,134,514.27	1,954,159,472.81
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	302,776,220.24	302,776,220.24
D08	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	1,695,910,734.51	2,256,935,693.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	453,379,900.00	437,699,853.62	15,680,046.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,379,900.00	437,699,853.62	15,680,046.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	431,809,600.00	419,104,353.62	12,705,246.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,772,200.00	259,705,200.89	4,066,999.11
210101	Үндсэн цалин	238,572,200.00	179,105,259.39	59,466,940.61
210102	Нэмэгдэл	0	31,429,000.76	-31,429,000.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	5,387,500.00	-5,387,500.00
210104	Урамшуулал	0	7,679,740.90	-7,679,740.90
210105	Гэрээт ажлын хөлс	25,200,000.00	36,103,699.84	-10,903,699.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,330,700.00	32,875,369.03	455,330.97
210201	Тэтгэврийн даатгал	22,779,700.00	22,499,205.19	280,494.81
210202	Тэтгэмжийн даатгал	2,637,800.00	2,601,947.30	35,852.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,110,200.00	2,074,698.42	35,501.58
210204	Ажилгүйдлийн даатгал	527,600.00	516,581.00	11,019.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,275,400.00	5,182,937.12	92,462.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,039,000.00	45,162,913.70	876,086.30
210301	Гэрэл, цахилгаан	5,164,700.00	5,958,321.70	-793,621.70
210302	Түлш, халаалт	40,874,300.00	39,094,482.00	1,779,818.00
210303	Цэвэр, бохир ус	0	110,110.00	-110,110.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,047,000.00	25,610,860.00	436,140.00
210401	Бичиг хэрэг	1,194,500.00	1,797,850.00	-603,350.00
210402	Тээвэр, шатахуун	21,650,100.00	21,650,020.00	80.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,725,700.00	1,052,190.00	673,510.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	508,500.00	91,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	876,700.00	602,300.00	274,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,854,800.00	18,851,800.00	3,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,160,000.00	7,160,000.00	0.00
210602	Тавилга	4,754,500.00	4,751,500.00	3,000.00
210604	Урсгал засвар	6,940,300.00	6,940,300.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	4,824,900.00	3,467,500.00	1,357,400.00
210702	Дотоод албан томилолт	4,824,900.00	3,467,500.00	1,357,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,633,500.00	2,149,010.00	484,490.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	950,000.00	950,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	109,000.00	109,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	497,500.00	165,310.00	332,190.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,000.00	111,700.00	152,300.00
210807	Газрын төлбөр	653,000.00	653,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,307,500.00	31,281,700.00	5,025,800.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,200,000.00	28,931,700.00	3,268,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,107,500.00	2,350,000.00	1,757,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,570,300.00	18,595,500.00	2,974,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,570,300.00	18,595,500.00	2,974,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	16,737,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,833,000.00	1,858,200.00	2,974,800.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	453,379,900.00	436,255,596.62	17,124,303.38
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	442,879,900.00	423,315,456.62	19,564,443.38
320001	Орон нутгийн төсвөөс	442,879,900.00	423,315,456.62	19,564,443.38
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,500,000.00	12,940,140.00	-2,440,140.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,500,000.00	12,940,140.00	-2,440,140.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	629,257.00	-629,257.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	53	53	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26	0.00
620001	Удирдах ажилтан	7	7	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	0.00
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00
620004	Гэрээт ажилтан	8	8	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	17,425,000.00	-17,425,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	17,425,000.00	-17,425,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	16,610,000.00	-16,610,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	810,000.00	-810,000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	810,000.00	-810,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	15,800,000.00	-15,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	15,800,000.00	-15,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	815,000.00	-815,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	815,000.00	-815,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосон	0.00	815,000.00	-815,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	17,425,000.00	-17,425,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	17,425,000.00	-17,425,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	17,180,000.00	-17,180,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	245,000.00	-245,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийн удирдлагыг мэдээлэлээр ханган, хууль тогтоомж хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар хүртээмжтэй хүргэх зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 302,776.2 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	629.2	0.0	-629.2
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	100,474.9	127,286.5	26,811.6
Үндсэн хөрөнгө	1,853,055.3	2,129,649.1	276,593.8
Нийт хөрөнгө	1,954,159.4	2,256,935.6	302,776.2
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,954,159.4	2,256,935.6	302,776.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,954,159.4	2,256,935.6	302,776.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 629.2 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 127,286.5 мянган төгрөг болж 26,811.6 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, аж ахуйн материал, бусад хангамжийн материал, мал амьтад нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,967,779.8 мянган төгрөг болж 27,589.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 13,857.3 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 397,950.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант онд 135,213.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Тайлант онд авлага, өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,256,935.6 мянган төгрөг болж 302,776.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон төсвөөс 439,798.7 мянга, давсан орлогоос 10,500.0 мянга, нийт 450,298.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 450,298.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 8,672.9 мянган төгрөгөөр бууруулж 441,625.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тавилга эд хогшил, тээвэр шатахуун, албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардлыг бууруулжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 11,754.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 442,879.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, нийт 453,379.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр орон төсвөөс 442,879.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 437,699.8 мянган төгрөг буюу 96.0 хувьтай, үндсэн данснаас 18,749.4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	237,534.4	229,389.6	8,144.9	96,5
2	80106- Баг хорооны ҮА-ны зардал	67,727.9	65,537.6	2,190.3	96,7
3	80111-Төрийн өмчийн барилгын тогмол зардал	52,469.2	51,984.8	484.4	99
4	80112-Нийтлэг үйлчигээ	40,528.2	39,562.2	965.9	97,6
5	80205-Мэдээлэл суртчилгааны зардал	750.0	750.0	0.0	100
6	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,833.0	1,858.2	2,974.8	38,4
7	80815-Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	16,737.3	16,737.3	0.0	100
8	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.0	14,675.0	325.0	97,8
9	81507-Мал тооллого	2,600.0	2,600.0	0.0	100
10	82212-Хур хог хаягдал, орчины бохирдол	600.0	508.5	91.5	85
11	82801-Улсын их баяр наадам	4,000.0	4,000.0	0.0	100
12	71413-81701 Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх	10,000.0	7,056.7	2,943.3	70,5
13	72208-81549 Ахмадын сан	600.0	600.0	0.0	100
14	70106-0000-Төрийн сан МХ-ийн эхний үлдэгдэл	629.2	0.0	629.3	0
	Дүн	453,379.9	437,699.8	18,749.4	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 17,180.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 245.0 мянга, нийт 17,425.0 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс Тээвэр шатахууны зардал 810.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 15,800.0 мянга, нийт 16,610.0 мянган төгрөг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 815.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 7,032.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 577,053.5 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 5,770.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 4,616.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж байхгүй.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд "Шинэ хөдөө Увс" төслийн шугамаар ирсэн "Сэлэнгийн халзан-Герефорд" үүлдрийн 3,997.3 мянган төгрөгийн 1 ширхэг өсвөр насны бух мал амьтад дансанд бүртгэсэн байна. Тухайн мал амьтныг гэрээ байгуулан иргэдэд эзэмшүүлсэн байх бөгөөд дараагийн аудитын хүрээнд ашиглалт, гэрээний үр дүнг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс						Зөвлөмж	
					Залруулсан		Залруулаагүй					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад таваргал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.БАТСУУРЬ/
/М.БАТ-АМГАЛАН/
/Б.ОДГЭРЭЛ/

2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр